

ПОПУЛЯЦЫН ШИНЖ ЧАНАР

Популяц нь биологийн макро системийн үндсэн нэгж учраас өөрийн гэсэн үндсэн шинжүүдийг агуулдаг.

Үүнд:

- Популяцын тоо толгой
- Популяцын нягтшил
- Үр төлөрхөг чанар
- Популяцын үхэл хорогдол





Популяцын тоо толгой

Популяцын тоо толгойн ерөнхий
өөрчлөлт:

- төрөлт
 - үхэл хорогдол
 - ирж суурьших \ иммигрици \
 - нүүж зайлж суурьших \эмиграци\
- гэх дөрвөн үзэгдлээс хамаарна.



Тухайн нутаг дэвсгэрт юмуу эсвэл
эзэлхүүнд байгаа нийт бодгалийн
ерөнхий тоог популяцын тоо толгой
гэнэ.

Популяцын тоо толгой

Популяцын тоо толгой дараах гурван хүчин зүйлтэй холбоотой бөгөөд түүнээс хамаарна.

- ❖ Популяцын суурьшлын нягтшил
- ❖ Абиотик хүчин зүйлийн нөхцөл, үйлчлэл (физик, уур амьсгал гэх мэт)
- ❖ Популяцын өөрийнх нь онцлог, бүтэц, бүрэлдэхүүн, олон янз хэлбэр гэх мэт
- Энэ бүх хэмжигдэхүүнээр популяцуудыг хооронд нь ялгаж болно.



Популяцын нягтшил

- Нэгж талбайн эзэлхүүнд оршин амьдарч буй бодгалийн тоо эсвэл биомассын дундаж үзүүлэлт юм.



Үр төлөрхөг чанар :

- Нэгж хугацаанд тухайн популяцид шинээр нэмэгдэж буй бодгалийн тоог төлөрхөг чанар гэнэ.
- Популяцын үхэл
- Тодорхой нэгж хугацаанд нэгэн биеийн хөгжилт зогсон мөхөж буй тусгаар бодгалийн тоо хэмжээг популяцын үхэл гэнэ.







Популяцын тоо толгойн хэлбэлзэл

Популяцын хэмжээнд дараах зүйлүүд нөлөөлдөг.

- Популяцын ашигтай хэмжээ-үржилд орох насны хүйсний бүтцээс ихээхэн хамаардаг. Хэрэв үржилд орох насны амьтад нь үржлийн дараах насны амьтдын тоо хэмжээнээс их байвал ашигтай хэмжээ юм.
- Үржлийн идэвхтэй радиус-Популяцын амьдралын туршид шилжин нүүдэллэх газар зүйн хэмжээг бодгаль биеийн буюу хувийн шилжилтийн радиус гэнэ.





Популяцын тоо толгойн хэлбэлзэл

Популяцын хоорондох тусгаарлалт, холбоо


Популяц он удаан жил оршин тогтнох нь бусад адил бүлгүүдээс тусгаар байхад хүргэдэг. Энэ нь 2 шалтгаантай.

- **Биесийн хоорондох өрсөлдөөн** (идэш тэжээл амьдрах нутгийн хүрэлцээ)
- **Шууд эсрэг тэсрэг зөрчилт байдал** (орон зайн, биологийн, бүтэц үйл ажиллагааны, физиологийн, зан төрхийн, генетикийн)










4.1 дүгээр график. Популяцын бодгалиудын тоо толгойн өсөлт

ПОПУЛЯЦ ӨӨРӨӨ ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ НЬ

- Английн экологич Д.Читти **“Популяц бүр өөрөө өөрийнхөө тоо толгойг зохицуулагч”** гэж үзсэн. Таамаглалаар популяц өөрөө өөрийнхөө тоо толгойг зохицуулах дараах 3 механизм байдаг.
- Нягтшил ихсэх үед бодгалиудын хоорондох харьцаа холбооны давтамж ихэссэнээс болж үхэл хорогдол ихэснэ.
- Популяцын нягтшил өсөх үед уугуул амьдрахад тохиромжтой нутгаас тохиромжгүй бүс нутаг руу нүүж хорогддог.
- Популяцын нягтшил өсөх үед популяцын генетикийн бүрдэлд өөрчлөлт гаран хорогддог.





уч

4.2 дугаар график. Махчин ба золиосын тоо толгойн хэлбэлзлэл